

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Үүнд:

-ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэг батлах тухай  
-Аймгийн ИТХ-ын Хороодын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

-Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар уламжлах тухай  
-Тогтоол хүчингүй болгох тухай

Аймгийн ИТХ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулж одоогийн байдлаар 16 төлөөлөгч оролцож санал солилцоод байна. Тус арга хэмжээний үеэр аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар төлөөлөгчдийг хүлээн авч уулзах, ажлын албаны бүрэлдэхүүнтэй уулзан санал бодлоо илэрхийлж, үйл ажиллагааны чиглэл, зөвлөмж өглөө.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай 2020 онд байгуулсан гэрээний үүргийн биелэлт, аймгийн ЗДТГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, аймгийн ЗДТГ-ын 2020 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 01-ний дотор хугацаанд нь хүргүүлжээ.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасны дагуу аймаг орон нутгийн онцлогт тохируулан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг аймгийн Засаг даргын 2021 оны 143 дугаар захирамжаар шинэчлэн батлуулж агентлаг, сумдад хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд Шуурхай штаб, байнгын хяналтын пост болон хөдөлгөөнт хяналтын постуудыг гарган Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар болон бусад төрийн байгууллагуудын давхардсан тоогоор 400 гаруй ажилтан, албан хаагчид хамтран үүрэг гүйцэтгэж аймаг, орон нутгаас орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж, иргэдийг бүртгэлжүүлж ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторын тасагт 354 сая төгрөгний өртөг бүхий Молекул биологийн иж бүрэн лабораторийн тоног төхөөрөөмж болох PSR-аппаратын хангалт хийгдэж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүх ажилчдад PCR шинжилгээ хийж, эхний байдлаар 2 тохиолдол батлагдан эмчилгээнд хамрагдан, Нэгдсэн эмнэлгийн Амбулатори, Халдвартын тасгийн нийт 49 ажилтан тусгаарлан ажиглалтад орсон. Коронавируст халдварын эсрэг вакцинжуулалт хийх бичил төлөвлөгөөг боловсруулж бэлэн болгосон.

Архангай МСҮТ дээр түргэвчилсэн шинжилгээний цэг байгуулж, Улаанбаатар хотоос PCR шинжилгээгүй ирсэн иргэдийг Цагаан хаалганы хяналтын постон дээр саатуулж, нийт 52 хүнд түргэвчилсэн шинжилгээ хийж бүгд сөрөг гарсан байна.

3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар коронавирусын батлагдсан тохиолдлын тоо 45, гэрийн ажиглалтанд 1442 хүн байна, 7.0 мянга, дам 2.0 мянган хавьтлын сорьцыг цуглуулж, ээлж дараатайгаар шинжилгээнд оруулж байна.

Сумдаас ирсэн 300 гаруй иргэнийг сөрөг шинжилгээний хариутайгаар орон нутагт нь буцаасан. ЕБС-д сумдаас ирж суралцдаг дотуур байр болон айлд байгаа 1400 гаруй хүүхдийн шинжилгээг авч суманд нь буцаах ажил хийгдэж байна.

Халдвартын тасгийн 30 ортой эмнэлэгт Хүүхдийн тасгийг нүүлгэн шилжүүлж, 62 ортой эмнэлэг байгуулсан бөгөөд цаашид 100 ортой эмнэлэг нэмж дэлгэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

### **Татвар төлөлт**

Орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 161.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 165.0 сая төгрөг төвлөрүүлэхээр, аймгийн төсөвт 838.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 850.0 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Суутгагч байгууллагын ТТ-12 тайлангийн хавсралт мэдээгээр төсөвт байгууллагад бараа материал нийлүүлсэн иргэдийн орлогын судалгааг үндэслэн 26 татвар төлөгчийг үйл ажиллагааны орлогын албан татвар төлөгчөөр бүртгэн 1960.2 мянган төгрөгийн нөхөн татвар ногдуулан төсөвт төвлөрүүллээ.

Хөрөнгийн татвар төлөгчөөр 2021 онд шинээр бүртгүүлсэн 57 иргэнээс 6125.1 мянган төгрөгийн албан татвар ногдуулан төсөвт төвлөрүүллээ

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

### **Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа**

2021 оны 3-р сарын 22-ны байдлаар 3717.4 төгрөгийн 9 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан бөгөөд зарласан 460.0 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээ, үнэлгээ хийгдэж байгаа 355.1 сая төгрөгний 4 төсөл арга хэмжээ, гэрээ байгуулах эрх олгосон 3262.3 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ тус тус байна. Төрийн худалдан авалтын газарт 2013-2020 онуудад олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулсан сумдын худалдан авалтын тайланг нэгтгэн явуулсан.

Орон нутгийн өмчит 14 төсөвт байгууллагад 56.4 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах, 1 төсөвт байгууллагад нэрийн 6.9 сая төг-ийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

### **Санхүүгийн хяналт**

Архангай аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Орон нутгийн өмчийн газарт хийсэн аудит, хяналт шалгалтаар Боловсрол, соёл урлагийн газарт улсын байцаагчийн 1 төрлийн актаар 343.5 мянган төгрөгийн төлбөр тогтоож, төсөвт нөхөн төлүүлэх, Орон нутгийн өмчийн газрын хяналт шалгалтаар улсын байцаагчийн 3 төрлийн актаар 208.4 сая төгрөгийн нөхөн төлбөр, 32.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага, 5 тэрбум 881.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон, бэлтгэгдсэн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр Аудиторын зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

“Архангайд үйлдвэрлэв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төвшрүүлэх сумын төсөвт албан байгууллагууд, Орон нутгийн хөгжлийн болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын байдалд төлөвлөгөөт аудит, хяналт шалгалтууд хийгдэж байна.

## **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд**

### **Хууль, хяналт**

Аймгийн хэмжээнд 2021 оны 3 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, осолын нийт 10 удаагийн дуудлага мэдээлэл ирсэнээс объектын гал түймэр 5 удаа, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга 1 удаа, эрэн хайх, аврах ажиллагаа 4 удаа тус тус гарч аж ахуйн нэгж, иргэдийн 40 байшингийн дээвэр, 375 хашаа хороо, 25 гэр нурж, 10 өндөр

хүчдэлийн шон унаж, 2 малын хашаа саравч шатаж, 68 мал амьтан хорогдож, 1 иргэн амь насаа алдсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт байршилтай эм ханган нийлүүлэх байгууллагын барилга байгууламжуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 20-ний өдрийн хугацаанд зохион байгуулж, шалгалтанд Монос-1, 2, Ази-Фарм эм ханган нийлүүлэх төв, “Эм эмпикс” ХХК-ын 3 салбар, Хаш, Цагаан сүмбэр, Өрнөх, Замбал, Хангай, Мөнгөт-Оюу, Нэгдсэн эмнэлгийн эмийн сан гэсэн нийт 10 байгууллагын 15 объект хамрагдаж Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 143 зөрчил илрүүлж 25 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 12, мэдэгдэл 3, танилцуулга 1-ийг тус тус бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А/106 дугаар захирамжаар зарим аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг тусгай нөхцөл шаардлагын дагуу, халдвар хамгааллын дэглэмийг сахиулан 3 дугаар сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар нээн ажиллуулж байгаатай холбогдуулан улсын хяналтын байцаагч нар үйл ажиллагаанд нь хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд Шуурхай штаб, байнгын хяналтын пост болон хөдөлгөөнт хяналтын постуудыг гарган Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар болон бусад төрийн байгууллагуудын давхардсан тоогоор 400 гаруй ажилтан, албан хаагчид хамтран үүрэг гүйцэтгэж аймаг, орон нутгаас орох, гарах хөдөлгөөнд хяналт тавьж, иргэдийг бүртгэлжүүлж ажиллаж байна.

Улсын Онцгой комиссоос өгсөн үүргийн дагуу /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 150 гаруй байгууллагуудад 37 төрлийн заавар, зөвлөмжийг тараан мэдээлэл өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт /маск/ зүүхийг уриалж ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайд 125 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ган, зудын эрсдэлийн” үнэлгээ хийх зааврын дагуу ХХААГ, Цаг уур орчин шинжилгээний газраас бэлтгэн гаргаж буй өвөлжилтийн бэлтгэлийг хангах болон цаг агаарын төлөв байдлын мэдээ, мэдээлэлд үндэслэн Архангай аймгийн зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэж Гамшгийн эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.

Коронавируст /ковид-19/ цар тахал халдвараас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 12.654 иргэнд хүрч хандалт авсан байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 5, шар усны үерээс урьдчилан сэргийлэх 4, гамшиг осол, аюулт үзэгдэлийн шторкыг “АВ” телевизээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 100 минут нэвтрүүлж урьдчилан сэргийлэх чиглэлээр 650 иргэнд ухуулга сурталчилгаа хийж 600 санамж гарын авлага тарааж ажиллалаа.

2021 оны 2-р сард аймгийн хэмжээнд 64 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22, малын хулгайн гэмт хэрэг 13, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 3, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 19, гэмт хэргийн илрүүлэлт 14.7 хувьтай байна.

Нийт 2623 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 2451 иргэнд 102135.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 133.4 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 33.9 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний алба 3-р сард криминалистикийн шинжилгээ 9, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 41, шүүх эмнэлгийн шинжилгээ 29, тусгай шинжилгээ 16-г хийсэн байна.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/58 дугаар тушаалаар 3-р сарын 1-ний өдрөөс танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн боловч коронавирусын тохиолдол илэрсний улмаас сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоосон.

“Гүрэн академи”, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран 6 сарын онлайн хичээлийг эхлүүлж байна. Уг сургалтад Архангай аймгийн ЕБС-ын сургалтын менежер, зарим мэргэжлийн багш нар хамрагдаж байна.

Цар тахлын үед ажиллах зөвлөгөө мэдээллийг өгөх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны яам, Дэлхийн зөн ОУБ, Онцгой байдлын ерөнхий газар хамтран “ЕБС болон цэцэрлэгийн гамшгийн эдсдлийн ерөнхий үнэлгээний арга зүй” сургагч багш бэлтгэх онлайн сургалтыг 3-р сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан.

## **Эрүүл мэнд**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Лабораторын тасагт 354 сая төгрөгний өртөг бүхий Молекул биологийн иж бүрэн лабораторийн тоног төхөөрөөмж болох PCR-аппаратын хангалт хийгдэж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүх ажилчдад PCR шинжилгээ хийж, эхний байдлаар 2 тохиолдол батлагдан эмчилгээнд хамрагдсан, Амбулатори, Халдварын тасгийн нийт 49 ажилтан тусгаарлан ажиглалтад орсон. Коронавирүст халдварын эсрэг вакцинжуулалт хийх бичил төлөвлөгөөг боловсруулж бэлэн болгосон.

Архангай МСҮТ дээр түргэвчилсэн шинжилгээний цэг байгуулж, Улаанбаатар хотоос PCR шинжилгээгүй ирсэн иргэдийг Цагаан хаалганы хяналтын постон дээр саатуулж, нийт 52 хүнд түргэвчилсэн шинжилгээ хийж бүгд сөрөг гарсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 3-р сарын 03-ны өдрийн А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Хүн амын эрүүл мэндийг дэмжих жилийн төлөвлөгөө”-ний дагуу “Эрүүл мэндийг дэмжигч байгуулах болох удирдамж”, “Эрүүл мэндийг дэмжигч сургууль болох удирдамж”, “Эрүүл мэндийг дэмжигч цэцэрлэг болох удирдамж”-ийг тус тус боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн.

Аймгийн 26 цэцэрлэгийн хүүхдийн хоол, 21 сургуулийн үдийн цайнд үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн.

Чулуут, Хайрхан суманд коронавирүст халдварын батлагдсан тохиолдол ирсэн мэдээллийн дагуу хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, 2 батлагдсан тохиолдлыг Улаанбаатар хотруу тээвэрлэж, ХӨСҮТ-д хэвтүүлсэн. Ойрын болон дам хавьтлуудыг тогтоох тандалт судалгааг хийж, гэрийн тусгаарлалтанд авч, ойрын хавьтлуудыг шинжилгээнд хамруулснаас Хайрхан суманд 1 тохиолдол батлагдсаныг Нэгдсэн эмнэлгийн коронавирүст халдварыг эмчлэх эмнэлэгт тээвэрлэн авчирч хэвтүүлсэн.

Өвөрхангай аймгийн Хужирт сумын “Сэмжид” рашаан сувилалд коронавирүст халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан тандалт судалгааг хийж, тус амралтанд 3-р сарын 01-ний өдрөөс хойш амарсан нийт 18 хүнийг тогтоож, гэрийн тусгаарлалтанд авч, шинжилгээнд хамруулснаас бүгд сөрөг гарсан.

ЭМГ-ын даргын 2021 оны 2-р сарын 23-ны өдөр баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 3-р сарын 2-ноос 7-ны өдрүүдэд ЭТҮХ-ийн даргаар ахлуулсан баг Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Батцэнгэл сумдын эрүүл мэндийн төвүүдийн яаралтай, түргэн тусламжийн бэлэн байдал, эх, хүүхдийн тусламж, сувилахуйн тусламж үйлчилгээ, анхан шатны бичиг баримт хөтлөлтөд явцын үнэлгээ хийж, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, чанар сайжруулах арга хэрэгслүүд ашиглах”, “эх, хүүхдийн тусламжинд мөрдөгдөж байгаа тушаал, зааврууд”, “хүүхдийн эрэмбэлэн ангилалт” сэдвүүдээр сургалт хийж, газар дээр нь зааварчилгаа өгч, зөвлөмж хүргүүлсэн.

## Соёл урлаг

Аймгийн Нийтийн номын сан улс орон даяар “Covid-19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд танхимын 30 хувийн дүүргэлттэйгээр уншлага-үйлчилгээг зохион байгуулж нийтийн уншлагын танхимаар 40 уншигч, 220 ирэгсдэд, 120 номоор, гэрээр ном олголтоор 100 ирэгсэдэд 110 номоор, хүүхдийн уншлагын танхимаар 12 уншигч шинээр бүртгэж, 242 ирэгсэдэд 204 номоор тус тус үйлчилсэн байна.

Өлзийт сумын бодонт багийн нутаг дахь Харганы дөрвөлжин гэх газар байрладаг Луут хотын дурсгалыг “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын хамгаалалтад” авах саналыг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн.

## Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2021 оны 3-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMS программд ажил идэвхитэй хайгч 1342 иргэн бүртгэлтэй байгаагаас 648 эмэгтэй. Шинэ ажлын байр 24 үүнээс байнгын ажлын байр 19, улирлын ажлын байр 4, түр ажлын байр 1 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 49, зуучлал 38 байна. Тухайн сарын 22-ны байдлаар 100 иргэн нь шинээр бүртгүүлж, LMS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилбал: боловсролгүй- 11, бага- 76, суурь-218, бүрэн дунд- 785, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 27, тусгай мэргэжлийн дунд-31, Дипломын бакалаврын-195 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 26 иргэнийг LMS программд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2021 оны 1-р улиралд 5 удаа хуралдаж, 139 хүүхдийн асуудлыг шийдвэрлэлээ. 1-р улиралд хурлаар орсон хүүхдүүдээс 6 хүүхэд шинээр, 112 хүүхэд сунгагдаж, 21 хүүхдийн биеийн байдал сайжирч, цаашид асаргаа шаардлагагүй гэж зогсоосон байна. Хурлаар орсон хүүхдүүдээс аутизмтэй-2, даунтай-3, сэтгэц оюуны бэрхшээлтэй-29, хөдөлгөөний бэрхшээлтэй-8, уналт таталттай-10, дотор эрхтний бэрхшээлтэй-26, хавдартай-4, харах эрхтний бэрхшээлтэй-5, гэмтэл, түлэгдэлттэй-4, бусад өвчнөөр-21 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатайг тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 3-р сарын 25-ны байдлаар нийт 5313.8 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 109 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 13.8 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 15.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1787,3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2020 онд 5313.8 сая төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 850.9 сая төгрөгөөр өссөн. Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

Тэтгэврийн даатгалын санд 65,5 % буюу 3485,7 сая төгрөг

Тэтгэмжийн даатгалын санд 7,3 % буюу 391,8 сая төгрөг;

ҮОМШӨ-ний даатгалын санд 5,6 % буюу 298,3 сая төгрөг;

Ажилгүйдлийн даатгалын санд 1,5 % буюу 84,7 сая төгрөг;

Эрүүл мэндийн даатгалын санд 20,1 % буюу 1053,1 сая төгрөг

## Гэр бүл, хүүхэд, залуучууд

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран “Хойч үеийнхэндээ хүргэх миний үг” захидлын уралдааныг зохион байгуулж үйл ажиллагааны үр дүнд эрэгтэйчүүдийн үзэл бодлоо илэрхийлэх, хойч үеийнхэндээ сургаал зөвлөгөөгөө үлдээх боломжийг бүрдүүлж, залуучууд үлгэр дуурайлал авч эр цэргийн алба хаах, эх орноо хамгаалах үйлсэд зүтгэх сэдэл тэмүүллийг бий болгосон.

"Эмэгтэйчүүдийн манлайлал" арга хэмжээг зохион байгуулахад байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн төлөөлөл 75 эмэгтэйг хамруулж, арга

хэмжээний хүрээнд “Эмэгтэйчүүдийн үнэ цэнэ”, “Эмэгтэйчүүдийн хувь хүний хөгжил”, “Гэр бүлийн харилцаа” сэвдүүдийн хүрээнд мэдээлэл өгсөн.

3-р сарын 05-ны өдрөөс эхлэн түр хамгаалах байраар үйлчлүүлж буй 1 үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээ 19 удаа, үйлчлүүлэгчид үзүүлэх нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ 15 удаа, хөгжлийн үйлчилгээнд 19 удаа үзүүлэн ажиллаж байна.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөс 5 насанд хүрэгч, 4 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгж, 1 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилсан. Төвийн пейж хуудсаар 15 удаагийн цахим постер мэдээлэл гаргаж, 4580 хүнд мэдээ, мэдээлэл хүргэсэн.

## **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

### **Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд энэ онд мал тооллогын дүнгээр 5399530 толгой мал өвөлжиж, хаваржиж байна. Үүнээс Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3 сумын 785 малчин өрхийн 115.8 мянган толгой мал хаваржиж байна. Бусад аймагт 48 малчин өрхийн 19.5 мянган толгой мал отроор, Архангай аймагт 5 аймгийн 40-өөд сумаас 214 өрхийн 98.3 орчим мянган толгой мал отроор, Аймаг дотроо Чулуут, Хангай, Тариат, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Жаргалант, Өлзийт, Өгийнуур, Хотонт, Төвшрүүлэх сумдын 117 өрхийн 56,6 мянган толгой өөрийн аймгийн бусад сумдын нутагт тус тус отроор өвөлжиж, хаваржиж байна.

Сумдын нөөц бүрдүүлэлт өвс 1328 тн, тэжээл 261 тн байснаас 90 хувийг малчдадаа зарж борлуулсан. Одоогоор сумдын нөөцөд 309 тн өвс, 113 тн тэжээл байна. Энэ онд Засгийн газрын 19 дүгээр тогтоолын дагуу аймгийн аюулгүй нөөцөд 325 тн өвс нөөцөлснөөс өнөөдрийн байдлаар нөөцөд 15 орчим тн өвс байгаа бөгөөд иргэд, малчдад 8500 төгрөгөөр өвсийг худалдан борлуулж байна. Хангай, Цахир, Чулуут, Хашаат сумдад зун гантай байсны улмаас малын идлэг муудаж хаваржилт хүндрэх төлөвтэй байна.

2020 оны мал тооллогын дүнгээр нийт 2385.8 мянган толгой хээлтэгч мал тоологдсон. Үүнээс 1908.7 мянган толгой эх малыг төллүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна. Өнөөдрийн байдлаар төллөвөл зохих хээлтэгч малын 0.1 хувь буюу 2822 толгой хээлтэгч мал төллөж, 2646 толгой төл малыг 93,8 хувьтай бойжуулж байна.

Аймгийн хэмжээнд нийт малын 0.7 хувь буй 38.5 мянган толгой мал зүй бусаар хорогдсон. Үүнээс 11.0 мянган толгой бод, 27.5 мянган толгой бог мал хорогдож Хотонт, Чулуут, Өндөр-Улаан, Ихтамир, Хангай, Цахир сумдад малын зүй бусын хорогдол их байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийг дэмжих” төслийн санхүүжилтийн хүрээнд зудын эрсдэлтэй нөхцөл байдалд өвөлжиж, хаваржиж буй амьжиргааны түвшин доогуур орлоготой, отроор яваа, тусламж дэмжлэг үзүүлэх шаардлагатай 1200 малчин өрхөд үзүүлэх тусламжийн хүнсний барааг 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр аймгийн Онцгой байдлын газартай хамтран хүлээн авлаа.

### **Газар тариалан**

2021 онд 10.3 мянган га-д үр тариа, 274 га-д төмс, 153 га-д хүнсний ногоо, 3.3 мянган га-д малын тэжээл, 1.0 мянган га-д тосны ургамал, 62.5 га-д жимс, жимсгэнэ, нийт 15.1 мянган га-д тариалалт хийж ургац хураалтын дүнгээр 10.3 мянган тонн үр тариа, үүнээс 9.9 мянган тонн улаан буудай, 2.7 мянган тонн төмс, 1.4 мянган тонн хүнсний ногоо, 8.4 мянган тонн малын тэжээл, 0.7 мянган тонн тосны ургамал, 43.7 тонн жимс, жимсгэнэ тус тус хураан авч, 9.8 мянган га-д уринш боловсруулж бэлтгэх зорилт дэвшүүлэн хаврын тариалалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хаврын тариалалт, уриншийн боловсруулалт хийхэд Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган сумын 50 иргэн, аж ахуйн нэгжид шаардагдах 2229 тн үр, 133 тн шатахуун, 3.7 тн хор, 45 тн бордоо, 50 литр ариутгалын бодисын захиалгыг авч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Хархорин дахь салбараар гэрээ байгуулж олгох ажлыг зохион байгуулж байна.

Хаврын тариалалтад ажиллах техник засварын ажлыг технологид хугацаанд хийж, 21 нэр төрлийн 653 техник, тоног төхөөрөмж ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна. тн үрийн захиалга авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Эрдэнэбулган суманд байрладаг 520 м<sup>2</sup> бүхий нийлэг хальсан 2 өвлийн хүлэмжийн цахилгааны хөнгөлөлтөд хамрагдах, 4 сумын 14 иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 35 ширхэг техник, тоног төхөөрөмжийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

#### **Барилга, дэд бүтэц**

2021 оны 3-р сарын 11-нээс 19-ний өдрийн хооронд иргэн, ААНБ-ын нэгж талбарын хувийн хэрэг, архивийг цахимжуулах зорилгоор Хангай, Тариат, Цахир сумдад ажиллаж нийт 1539 цаасан суурьтай хувийн хэрэг, 12965 хуудас материалыг Ланд менежер программын мэдээллийн санд оруулсан.

Засгийн газрийн 2017 оны 68-р тогтоолоор батлагдсан барилгын ажлын эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн дагуу Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийг баримтлан 3-р сард иргэн Шинэбаатарын 24 айлын орон сууц, иргэн М.Батболдын 36 айлын орон сууц, иргэн Ж.Нэргүйгийн 24 айлын орон сууцны барилгуудад ажил эхлүүлэх зөвшөөрөл олголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----